



ХАРИЛЦАН ХАМААРЛЫН ТУНХАГЛАЛ

One Shared.World (Хамтын нэг ертөнц) нь хүн төрөлхтөнд илүү сайн ирээдүйг цогцлоож, тогтвортой байдлыг хангах зорилгоор төрөл бүрийн соёл, хамтын нийгэмлэг, үндэстэн ястан, байгууллага, бүтэц, ашиг сонирхлын бүлэг, үе үеийнхэн болон үндэстэн хооронд хамтран ажилладаг оролцогч талуудыг хамарсан өргөн хүрээний хөдөлгөөн юм.

Манай дэлхийн хүчний тогтолцооны чухал тулгуур багана болох нийт хүн төрөлхтний ардчиллын илэрхийллийг хөхиүлэн дэмжих, бидний нэн шаардлагатай хамтын хэрэгцээг хангахад чиглэсэн туршлага, бүтэц, тогтолцоо болон үр дүнд бодит өөрчлөлтийг бий болгохыг бид эрэлхийлнэ.

Оршихуйн нийтлэг сорилттой нүүр тулж буй нэг хүн төрөлхтөн гэдэг сануулгыг КОВИД-19 цар тахал бидэнд маш хүчтэй өгснийг хүлээн зөвшөөрснөөр бид:

Гагцхүү өөр хоорондоо болон манай гараг дээр оршиж буй төрөл зүйл, экосистемтэй нягт харилцан хамааралтай гэдгээ хүлээн зөвшөөрснөөр бид хамтын хүчээр эрүүл, аюулгүй, тогтвортой ирээдүйг амжилттай цогцлоох үйлсэд хүчин чармайлтаа зориулахад *санал нэгдэж*,

Бүх нийтийн сайн сайхны төлөөх хамтын үүрэг хариуцлагаа *ухамсарлаж*,

Хүн төрөлхтний сайн сайхан хүн бүрээс эхлэлтэй бөгөөд бидний хүч чармайлтын зорилго, үйл ажиллагаа, хүсэн хүлээгдэж буй үр дүн зэрэг нь гагцхүү уялдаа холбоотойгоор хэрэгжихийг *нотолж*,

Энэхүү хямралт цаг үед ч гэсэн бидэнд тулгарч буй аюул занал нь илүү сайн, гэрэлт ертөнцийг бий болгох бидний хамтын хүчийг улам бүр бадрааж буйд *итгэж* байна.

Иймээс One Shared.World (Хамтын нэг ертөнц) дараах тунхаглалыг баталж байна. Үүнд:

НҮБ-ын Дүрэм, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Тогтвортой хөгжлийн зорилтуудад тусгалаа олсон хүн төрөлхтний нийтлэг бөгөөд амин чухал хүсэл тэмүүллийг бид тууштай дэмжинэ.

Дэлхий дахинаа энх тайван, аюулгүй байдал, тогтвортой байдал, сайн сайхныг ханган бэхжүүлэхэд улс орнууд болон олон улсын байгууллагууд ихээхэн хувь нэмэр оруулсан боловч бидний нийтлэг хэрэгцээ, шаардлагыг шийдвэрлэхэд хүчин мөхөсдөж байгаа нь илэрхий байна.

Дараах болон бусад үйлдэл буюу эс үйлдэхүй нь дээрхийг нотолж байна. Үүнд:

- КОВИД-19 зэрэг дэлхий нийтийг хамарсан цар тахлыг урьдчилан тогтоох, урьдчилан сэргийлэх, улмаар хариу арга хэмжээ авах дэд бүтэц байгуулж чадаагүй;
- Цөмийн, химийн, кибер болон бусад үй олноор устгах зэвсгийг дэлгэрүүлэх үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлж чадаагүй;
- Уур амьсгалын өөрчлөлтийг зогсоож, байгаль орчны доройтлоос урьдчилан сэргийлж, манай дэлхийн тогтвортой байдал болон байгалийн бүх төрөл зүйлийг хадгалж хамгаалж чадаагүй;
- Бидний дунд амьдарч буй хамгийн эмзэг бүлгийн хүмүүсийг өлсгөлөн, тэжээлийн дутагдал, ялгаварлан гадуурхал, халдварт өвчин болон эмх замбараагүй байдлаас хамгаалж чадаагүй;
- Хүн төрөлхтний хамтын баялаг болсон далай тэнгис, агаар мандал, сансар огторгуй ба санхүүгийн тогтолцооны менежмент, цаашлаад хүчирхэг технологи ашиглах үйл явцад бидний нийтлэг, нандин үнэт зүйлсийг тусгах бүтцийг бий болгож чадаагүй.

Дээрх сорилтуудыг даван туулж чадаагүй нь нэг гараг дээр амьдарч буй хэдий ч Засгийн газруудын тэргүүлэх чиглэлүүд хүн төрөлхтний хамтын хэрэгцээ шаардлагатай зөрчилдөж буйтай холбоотой юм. Улс орнууд болон олон улсын байгууллагуудын үйл ажиллагаа чухал хэвээр байгаа хэдий ч бид хамтын ажиллагааны үзэл баримтлал, чадавхиа өргөжүүлэх замаар л дэлхийн хэмжээний сорилтуудыг даван туулж чадна.

Энэ хүрээнд бид бүрэн эрхт улс орнууд болон тэдгээрийн үүсгэн байгуулсан олон улсын гол байгууллагуудаас ангид дэлхийн хүчний тогтолцооны гурав дахь баганыг босгохоор зорьж байна. Энэхүү гурав дахь багана нь хүн төрөлхтний нийтлэг ардчиллын илэрхийллийг төлөөлөх улс төрийн хүчин бөгөөд дэлхий дахины хүртээмжтэй нийгмийн хөдөлгөөн юм.

Хүмүүнийхээ хувьд бидний нийтлэг хүсэл тэмүүллийн хүч нь улс орнууд болон олон улсын байгууллагуудын нэгэнт хийсэн бүтээлч ажлыг орлох бус тэдгээрийг дэмжих, урамшуулахад оршино гэдэгт итгэж байна.

Үндэсний болон глобал нийтийн эрх ашгийг газарзүйн байрлал болон үе үеийн төлөөлөлд жигд, харилцан ашигтай байдлаар хангах зохистой шийдвэр гаргах үйл явцыг төлөвшүүлэх амлалт өгөхийг улс орон, байгууллагуудын бүх шатны манлайлагч нараас бид хүсч байна.

Манай хөдөлгөөн нь орон нутгийн, бүс нутгийн, үндэсний, олон улсын түвшинд хамтран ажилладаг хувь хүн, байгууллага болон бусад бүтцээс бүрдсэн сүлжээнд суурилах ёстой гэж бид үзэж байна.

Шинэ технологи нь түүхэнд байгаагүй хамтын ажиллагааны боломжийг олгож буйг бид талархан хүлээн авч байгаа ч энэхүү ажиллагаанд оролцох ёстой хүмүүс уг глобал харилцаа холбооны сүлжээнд хараахан холбогдоогүй байна.

Ялгаатай байдал нь бидний үлэмж чадавх гэдгийг хүлээн зөвшөөрч бид энд нэгдсэн хувь хүнийхээ хувьд, цаашлаад хамтын нийгэмлэг, байгууллага болон бусад бүтэц, үндэстний төлөөллийн хувьд өөр хоорондын харилцан хамаарал, хамтын үүрэг, хариуцлагаа зарлан тунхаглаж байна.

Бид:

1. Бидний өмнө тулгарч буй оршихуйн аюул заналыг урьдчилан тогтоох буюу түүнээс сэргийлэх, улмаар хариу арга хэмжээ авах дэд бүтэц байгуулахыг дэмжих;
2. Бидний дунд амьдарч буй хамгийн эрх мэдэлгүй хүмүүс нэр хүндтэй бөгөөд хүчирхэг нэгэнтэй адил эрх чөлөөг эдлэх, ялгаатай хэдий ч хүн хоорондын эв нэгдлийг хангах, хүн бүр нэр төртэй амьдрах нөхцлийг дэмжих;
3. Хамтын нийгэмлэг, байгууллага ба бусад бүтэц болон үндэстнээр дамжуулан хүн төрөлхтөн бидний дундын гэр болох дэлхий ертөнцийг хамгаалах;
4. Дэлхий дээр орших бүх төрөл зүйл болон экосистемийг тэтгэх эрүүл бөгөөд тогтвортой хүрээлэн буй орчныг бүрдүүлэх;
5. Хүүхэд бүр, хүн болгоны эрүүл мэнд, аюулгүй байдал, сайн сайхныг баталгаажуулж, боловсрол, эрүүл мэнд ба нийгмийн хамгааллын үйлчилгээг жигд хүртэх нөхцлийг бүрдүүлэх;
6. Соёл хоорондын холбоо, харилцан хүндлэл, утга учир, уялдаа холбоог бий болгоход чиглэсэн урлагийн хөдөлгөөний бүх хэлбэрийг дэмжиж түгээх;
7. Харилцан ойлголцол, хүндлэл, хүнлэг энэрэнгүй зан байдлаар дамжуулан хүн хоорондын харилцааг хөгжүүлэн дэмжихээ тус тус амлаж байна.

Энэхүү тунхаглалд нэрээ оруулснаараа бид дээрх зарчмуудыг хэрэгжүүлэхэд өөрсдийн боломжийг бүрэн зориулж, бидэнд тулгарч буй сорилтуудыг хамтын хүчээр даван туулахад хүчээ нэгтгэхийг бүх хүн, байгууллага болон бусад бүтэц, үндэстэнд уриалж байна.

Иймд олон улс орны төлөөлөл болон хамтын ертөнцийн иргэд бид амьдралын эрч хүч, ирээдүйн хувь тавилан, ариун нэр төрөө бие биедээ зориулан дайчлахаа харилцан амлаж байна.